



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/397

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.11 дэх заалт, Засгийн газрын 2025 оны “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 133 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1038, А/1617 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийг хийн түлшний хэрэглээнд хэсэгчлэн шилжүүлэх төслийн хүрээнд хийн түлшээр хангах борлуулалтын (баллон түгээх) цэгийг стандартын дагуу барьж байгуулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Дүүргийн менежер

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Г.Галбадрах /зөвшилцсөнөөр/

1525012251

Таван толгой түлш ХХК-ийн Төслийн
удирдлагын газрын менежер
М.Ариунжаргал /зөвшилцсөнөөр/

Таван толгой түлш ХХК-ийн Төслийн
удирдлагын газрын Хөтөлбөр
зохицуулалтын хэлтсийн дарга
Ж.Эрхэмбаяр /зөвшилцсөнөөр/

Таван толгой түлш ХХК-ийн Төслийн
удирдлагын газрын менежер
М.Ариунжаргал /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын
стандарт, тохижилт нийтийн аж ахуйн
хэлтсийн Агаар, орчны бохирдолтой
тэмцэх тасгийн дарга

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад тухай
бүр танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг ажлын хэсэг (Д.Уянга)-т үүрэг
болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын
газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ